

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛД

Т.ДОРЖДАГВА¹, Т. ЭНХТУНГАЛАГ²

¹ МУИС, НШУС, Философийн тэнхим

² МУИС, НШУС, Философийн тэнхим

Түлхүүр үг: Шинжлэх ухаан, технологийн ёс зүй, биоэтик, "хүмүүнлэг чадвар", "Шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хөтөлбөр", "Дэлхийн шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хороо" (COMEST)

Товч утга: Зохиогчид өгүүлэлдээ шинжлэх ухаан, технологийн асуудлыг соёлын онолын шагайлбараар дурандаж, шинжлэх ухаан, технологи нь "хүмүүнлэг чадвар" байж гэмээж нь ёс зүйтэй байж, өндөр соёл болохын учрыг гаргаж, "Шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хөтөлбөр"-ийн ач холбогдол, "Дэлхийн шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хороо"-ны зорилго, зорилтуудтай холбогдуулан өөрсдийн санаа бодлыг илэрхийлсэн байна.

Шинжлэх ухаан бол хүн төрөлхтний оюуны соёлын нэн чухал салбарын нэг билээ. Шинжлэх ухааныг хүн төрөлхтөн үеийн үед дээдлэн хөгжүүлж, түүний ололт, үр шимийг хүртсээр ирсэн байна. Ертөнцийн түг түмэн юмс үзэгдлийн нууцад нэвтэрч, үнэнийг хайж, түүнийг илрүүлэх чадвар бол өндөр соёл болно. Хүн төрөлхтөн үүний ачаар гадны нөлөөнөөс ангижирч, өөрийн хүч чадвартайд итгэн үнэмшиж, ертөнцийг өөрийн хүсэл зорилгодоо нийцүүлэн өөрчилж, материаллаг хийгээд оюуны хэрэгцээгээ хангасаар иржээ.

Гэтэл шинжлэх ухааны хөгжил дан ганц сайн сайхныг хүнд өгсөнгүй, бас саар муу нөлөөллийг нэгэн адил дагалдуулсан байдаг. Үүнтэй холбогдуулан бид шинжлэх ухааны ёс зүйн асуудлыг энэ удаа хөндөн ярих зорилго өвөрлөсөн болно.

Шинжлэх ухаан, техник, технологийн үсрэнгүй хөгжил хүн олныг хөнөөх, үгүйдээ хохироох олон арга хэрэгслүүдийг буй болгожээ. Тэрээр ХХ зуунд цөмийн, химийн, биологийн зэвсгийг, тэрчлэн нийтэд асар их хөнөөл үзүүлэх бусад олон зүйлийг буй болгосон байна. Тухайлбал, дэлхийн бүхэл бүтэн мужийг хамарсан газар хөдлөлт үүсгэх чадвартай тектоник зэвсгийн тухай ч ярих болж /4. 435/. Амиа бодох үзэл, хорон санаа, өөдгүй зан үйл урьд өмнө нь хэзээ ч ийм сүйтгэгч хүчтэй байсангүй. Дайн байлдааны хэрэгцээ шинжлэх ухааны хөгжлийг урагшлуулж, шинжлэх ухаан, техник нь сүйтгэлийн боломж хэмжээг хичнээн дахин нэмэгдүүлснийг олон баримтаар нотлон ярьж болно. Эдүгээ шинжлэх ухаан, техник зөвхөн хүний бие махбодид нөлөөлөөд зогсохгүй, түүний сэтгэл санаа, дотоод ертөнцөд ч

нөлөөлж байна. Хүн зонд анхандаа уламжлал, зан заншил, ёс горим, сүсэг бишрэл л байлаа. Харин одоо олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хөгжил хүний ухамсрыг удирдаж хөтлөх урьд өмнө хэзээ ч үзэгдээгүй боломжийг буй болгосон байх юм.

Энэ болгон маань хүний эрх, чөлөөт байдалд тохирч байгаа билүү? Энэ илтгэлийн эхэнд бид шинжлэх ухаан бол өндөр соёл юм гэж дээр хэлсэнсэн. Гэтэл соёл нь "хүмүүнлэг чадвар" баймаар атал хэдхэн мөрийн дараа бас "хүмүүнлэг бус чадвар" мөн болдог нь илэрдэг байна шүү. Тэгэхлээр шинжлэх ухаан хүн төрөлхтний сайн сайхныг бэлгэдэж, хүмүүний материаллаг болоод оюуны хэрэгцээг ханган ая таатай нөхцөл байдлыг бүрдүүлэх гол хэрэгслийн нэг гэж үздэг тогтсон хандлага эргэлзээтэй болж ирдэг. Ийм учраас шинжлэх ухааны ёс зүйн тухай ярихгүй бол яав ч болохгүй л цаг үед бид хүрэлцэн ирсэн байгаа биз дээ.

Шинжлэх ухааны ёс зүйн нэг чухал асуудал бол биоэтикийн асуудал юм. Энэ асуудал анх эрхтэн шилжүүлэх үед босож ирсэн юм байна. Өөрөөр хэлбэл ямар нөхцөлд эрхтэн шилжүүлж суулгахыг хориглох вэ гэдэг асуудлаас үүджээ. Хүний эрхтэнийг авахын тулд түүнийг үхүүлэх ёстой юм уу? Ер нь хүний эрхтэнийг дамлан худалдах увайгүй явдал гарсаар байх уу? гэсэн асуултууд зүй ёсоор гарч ирж байна. Амьдралаа залгуулахын эрхээр нүд юмуу, бөөрөө худалдах тохиолдол ч гарч байдаг бололтой. Судлаачдын үзэж байгаагаар ирээдүйд иймэрхүү асуудал илүү ноцтой нөхцөл байдлыг төрүүлэх боломжтой ажээ. Энд бас л соёл хүмүүнлэг байх ёстой гэсэн нөгөө зарчим сөхөгдөж байна.

Биологийн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтууд ёстой л хүний нүдийг бүлтийлгэж, чихийг дэлдийлгэж байгаа юм. Жишээ нь: организмын эсээс түүний бүрэн хуулбарыг буй болгох тухай буюу клонийн аргыг хэлж болно. Онолын хувьд (хэрэв санхүүгийн асуудлыг шийдчих юм бол) генетикийн ижил кодтой, ижил авьяас чадвартай хүмүүсээс бүрдэх бүхэл бүтэн улс орныг буй болгох боломж байна гэж хэлж болно. Ингэснээр генийн хувьд ялгаатай давхраажилт, биологийн кастуудад нийгмийг хуваах нөхцлийг бий болгох нь. Энэ нь нэг хэсэг хүнийг бусдын эрхэнд оруулж, зарим хүний төрөлх эрх "дэнслэгдэх" биологи лүндэн бий болгоно гэсэн үг. Цаашилбал хүн төрөлхтөн чадавхийн хувьд ядмагжиж, мөхөлд хүрэх эрсдэлтэй тал руу хүрч болох юм.

Хүний генийн аппарат руу нэвтрэх нь урьдчилан хэлэхийн аргагүй үр дагаварт хүргэж болох аюултай зүйл болно. Амьтдыг генетикийн хувьд

эвцэлдүүлэх туршилт нь аль хэдийнээ хийгджээ. Шинжлэх ухаан хүний чадвар, ухамсрыг биедээ шингээсэн үл танигдах, аймшигт араатныг зарчмын хувьд бий болгох бололцоотой байгаа юм /4. 438/. Энэ нь өнөөдөр аль хэдийнээ уран зөгнөл биш болсон буюу харин ч бодох, гарц хайж олох ёстой асуудал болоод байна шүү дээ.

Философи, анагаах ухаанд эдүгээ хүртэл яригдсаар байгаа ужиг асуудлын нэг бол эвтанази мөн бөгөөд энэ нь удаан хугацаагаар өвдөж шаналахын оронд хялбар үхлийг өөрөө сонгох тухай асуудал юм. Шашинд үүнийг "амиа хорлох үйл", "санаатай аллага" хэмээн үзэж эсэргүүцдэг бол эмч нар мэргэжлийн ёс зүйнхээ дагуу эцсийн мөч хүртэл өвчтөнийг аврахын төлөө тэмцэх үүрэгтэй байдаг. Мөнгөлчүүдийн түүхэнд нүүдлийн аясыг даахгүй болсон хөгшин эцгийнхээ хүссэнээр төрсөн хүү нь эцгээ бурхан болгодог ёс заншил байсан гэдэг. Тэрээр эцэгтээ хонины сүүлийг үмхүүлж, чөмөгний ясаар гударч хахуулаад ёсыг гүйцэтгэдэг байсан гэж ярьцгаах нь бий. Зовлонгоос түргэн салах гэсэн өвчтөний хүслийг эдгэрэх боломжтой хүнийг хорон санаагаар егүүтгэх санаархлаас салгаж ойлгоход төвөгтэй байдаг. Энэ нь хүнд өвчтөний үхэх эрх, түүнд нигүүлсэнгүйгээр туслах боломжийн тухай шийдвэргүй асуудлыг үлдээсээр байдаг байна.

Нөгөө талаар амьдрах чадвар сул болон эрхтэн согогтой нярайн амийг орчин үеийн анагаах ухаан аварсаар байгаа ч, эмгэг нийгмийн хүрээг тэлсээр байхад хүргэж байдаг нь илэрхий юм. Энэ нь хүн төрөлхтөн бүхэлдээ сул дорой болж хувирахад нөлөөлөх нь ойлгомжтой. Энэ мэт олон асуудлыг хөндөж болох ч тэдгээрийг үүгээр товчлон өндөрлөө гэж бодож байна.

Энэ бүгдээс үзэхэд шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн өмнө ёс зүйд холбогдох олон асуудал улам бүр нэмэгдэн гарч ирсээр байгаа нь тодорхой байгаа бөгөөд тэдгээрийг шийдвэрлэх аргыг "хүмүүнлэг" ба "хүмүүнлэг бус" гэж ялгах заагийн тухай асуудал чухал болох нь харагдаж байна. Энэ бол үнэлэмжийн тухай асуудал, өөрөөр хэлбэл тэдгээрийг ялгах чадварын асуудал нь философи, соёл судлалын тулгамдсан асуудлын нэг мөн гэж үзэж болно.

Шинжлэх ухаан, технологийн өндөр хурдацтай дэвшлийн чадавхийг үр өгөөжтэй ашиглах зорилгоор шинжлэх ухаан, технологийн ёс зүй хийгээд түүний ашиглалтын асуудлыг нягт уялдаатай авч үзэж хөгжүүлэх нь зүйд нийцэх ёстой бизээ. Энэхүү хэрэгцээг илүү гүнзгий танин мэдэх зорилгоор "Шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хөтөлбөр"-ийг 1998 онд ЮНЕСКО-гоос гаргаж, улмаар "Дэлхийн шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хороо"

(COMEST)-г тэр үед үндэслэн байгуулсан ба уг асуудал 2002 оноос эхлэн ЮНЕСКО-гийн анхаарлын төвд байх тэргүүлэх чухал асуудлын нэг болжээ /1/.

Энэхүү хороо нь дараах хэд хэдэн зорилтуудыг хэрэгжүүлдэг байна:

1. Шинжлэх ухаан, технологийн ёс зүйн хөтөлбөрт холбогдох асуудлаар байгууллагуудад зөвлөгөө өгөх;
2. Хороо нь үзэл санаа болон туршлагаа нээлттэй солилцох, оюунлаг чуулга уулзалт хэлбэртэй ажиллах;
3. Энэ үндсэн дээр эрсдэлт нөхцөл байдлын түрүү илрэлүүдийг олж илрүүлэх;
4. Энэ талаар шийдвэр гаргагчдад зөвлөгчийн үүрэг гүйцэтгэх;
5. Шинжлэх ухааны нийгэмлэг, шийдвэр гаргагч болон олон нийт хоорондын харилцааг өрнүүлэх зэрэг болно /1/.

Унгарын Будапешт хотноо 1999 онд болсон "Дэлхийн шинжлэх ухааны бага хурал" дээр ёс зүй болон шинжлэх ухааны хариуцлагын асуудлыг авч үзээд дараах зөвлөмжийг бас гаргасан байдаг. Энд:

- Боловсролд шинжлэх ухааны ёс зүйн эзлэх байр суурийг нэмэгдүүлэх;
- Шинжлэх ухааны ёс зүйн асуудлаар үндэсний бие даасан бүтцийг байгуулах;
- Шинжлэх ухааныг болон судалгааны бүх салбарыг удирдан хөтлөх улс хоорондын байгуулалгыг буй болгож, үйл ажиллагаанд оруулах;
- Шинжлэх ухааны урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх;
- Олон нийттэй нээлттэй харилцаа холбоог бий болгох /1/ зэргийг оруулжээ.

Тийм учраас үндэсний соёлын хэмжээнд үл шийдвэрлэгдэх буюу шийдвэрлэхэд ноцтой байдалд хүргэж болох зарим асуудлыг дээр дурдсан хороонд уламжлан тавьж судлуулаад зөвлөмж гаргуулан авч асуудалд эрх зүйн үндэстэйгээр хандаж болох бололцоог бид ашиглаж байх нь зүйтэй бизээ. Бас уг асуудлаарх үндэсний бие даасан бүтцийг аль нэгэн хэлбэрээр буй болгож, олон улсын хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулбал зохилтой хэмээн үзэж байна. Энэ талаар бид зарим боломжуудыг ашиглаж чадахгүй алдаж байгаа байж ч мэдэх юм.

Өөр нэг асуудал бол эрдэм судалгааны ажилд хамрагдагчдад холбоотой асуудал юм. Америкийн социологич Мертон /1910/ "Шинжлэх ухааны хэм хэмжээлэг ёс зүй" гэдэг ойлголтыг харьцангуй нухацтай боловсруулсан байна. Түүний үзсэнээр шинэ европын шинжлэх ухааны ёс

зүй гурван үндсэн хүчин зүйлээр тодорхойлогдох ажээ. Энэ нь нэг талаас, үнэн, мадаггүй мэдлэгийн хүрээг тогтолцоожуулан тэлэх нь шинжлэх ухааны үндсэн зорилгод тохирох, нөгөөтэйгүүр ашигтай гэх үзэл, рациональ чанар, индивидуализм хийгээд уламжлалыг эсэргүүцэх үзэл зэрэгт онцгой ач холбогдол өгөх, бас ардчилсан, иргэншсэн зан үйлийн үндсэн стандартыг хэрэгжүүлэх зэрэг болно. Эндээс үзвэл Мертон эрдэмтний үйл ажиллагааг зөвхөн танин мэдэхүйн төдийгүй, мөн нийгмийн холбогдол бүхий талаас нь авч үзсэн нь тодорхой байна.

Тэрээр шинжлэх ухааны ёс зүйн 4 үндсэн императивыг эрдэм судалгааны эргэлтэнд оруулсан байна:

1. Эрдэмтэн хүн өөрийн болоод бусдын судалгааг үнэлэхдээ аль нэг ашиг сонирхол, эсвэл үл таашаах үүднээс бус, харин шинжлэх ухааны мэдлэгийг нотлож, үндэслэх ерөнхий шалгуурын үүднээс хандах ёстой;

2. Шинжлэх ухааны үйл ажиллагааны үр дүнг тухайн салбарынханы, цаашилбал нийгмийн хамтын үйл ажиллагааны үр дүн гэж үзэх ёстой;

3. Сайн үндэслэгдсэн үндэслэл, баримтыг өөрийн итгэл үнэмшилтэй зөрчилдөж байсан ч (хэрэв няцааж чадахгүй бол-Т.Д.) хүлээн зөвшөөрөх ёстой;

4. Өөрийн ололтыг үнэлэхдээ өөрийн шүүмжлэлийг зайлшгүй тогтоох, мэдлэгийн тогтвортой өсөлтийг хангах үүднээс рациональ шүүмжлэлд идэвхитэй оролцох ёстой гэжээ.

Эдгээр хэм хэмжээнүүдийг зөрчих, эсвэл баримтлахгүй байх нь шинжлэх ухааны нийгэмлэг бүхэлдээ уналтанд орох, мэдлэг үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүний чанар муудах, хуурамч шинжлэх ухааны төрлүүд үүсэж гарахад хүргэдэг байна. Бид эдгээртэй үндсэндээ санал нэгтэй байгаа болно.

Гэтэл манай амьдрал практикаас харж байхад дээр дурдсанаас санаа авмаар зүйл бишгүйдээ ажиглагдаж байдаг. Бидний зарим нь зөвхөн өөрийн ажлыг дөвийлгөж, бусдын ололтыг дорд үзэх, тэдгээрийг үнэлэхийг үл хүсэх, гартаа барьж, уншиж үзээгүй хэрнээ муучлах хачин араншинд сэхэл авахааргүй идэгдсэн байх нь харамсалтай. Бас өөрийн хэт хуучин итгэл үнэмшилдээ хүлэгдэж, бусдын үзэл санаа, саналыг ямар ч нотолгоогүйгээр нухчин дарж, өөр бодол, эргэцүүллийг хүлээж авах тэнхэлгүй болтлоо доройтсан нь ч бий. Өөрөөр хэлбэл шинэсрэг юмыг хүлээж авах "савгүй" болчихож гэж хэлж болно. Нөгөө талаар нэг хэсэг нь рациональ шүүмжлэл өрнүүлэхээс айж, явцуу тодорхой хүрээлэлд асуудлыг шийдэн амь аргацаах арга барилд сүрхий дадсан харагдаж байгаа юм. Мэтгэлцээний соёлд нэг л

суралцаж өгөхгүй байгаа юм даа. Ийм нөхцөлд мэдлэгийн тогтвортой өсөлтийг хангах асуудал ярилтгүй гэдэг нь ойлгомжтой буюу.

Ашигласан бүтээл

1. [http; //www.unesco.org/science/wcs/background/ethics.htm](http://www.unesco.org/science/wcs/background/ethics.htm)
2. [http; //www.ntua.gr/dep/SYS/Ethics/Ethics-UNESCO.htm](http://www.ntua.gr/dep/SYS/Ethics/Ethics-UNESCO.htm)
3. [http; //www.cseserv.engr.scu.edu/NQairn/ENGR019-301winter2002/UNESCO declaration_ehtm](http://www.cseserv.engr.scu.edu/NQairn/ENGR019-301winter2002/UNESCO%20declaration_ehtm)
4. Золотухина-Аболина Е.В. Современная этика: Истоки и проблемы. Учебник для вузов. – Ростов н/Д: Издательский центр “МарТ”, 2000. – 448 с.